МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг
Том. XXX (318) 2009 100-108

МОНГОЛ ХЭЛНИЙ "БЭЛЧИР" ХИЙГЭЭД "БЭЛЧИРЛҮҮЛЭХҮЙ" ГЭДЭГ ҮГИЙГ УТГА, СОЁЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЛААС НЬ ШИНЖЛЭХҮЙ

Б.Пүрэв-Очир[1]

Үгийг найруулна гэгч үйлдэхүйеэ бэрх үзэсгэлэнт чимэг мөн.
Утгыг найруулах гэгч үйдал үгүй анхааран авахын ёсон мөн.
(Агванхайдав)

1.Үг ба утгаас үүдүүлэн…

Монгол хэлний **"бэлчир"** гэдэг нэр үг, **"бэлчирлэхүй"** ба **"бэлчирлүүлэхүй"** хэмээх үйл үг нь үгийн сан – утгазүйн талаасаа болон хэрэглээ, соёлын айн талаасаа тун өвөрмөц утга, үүрэг, өнгө аясыг тээж ирсэн байж магад юм. Сав ба шим ертөнцийн юм, үзэгдлийн зогсонги ба хөдлөнги тал, арга ба билгийг илэрхийлсэн энэ хоёр үг бол нүүдэл шүтсэн монголчуудын амьдрах ухаан, хэл, сэтгэхүйн холбоо, гэгээрэл боловсрол, соёл заншил, тэрчлэн ярианы ба бичгийн хэлэнд холбон найруулах, эвсүүлэн найруулах, утгыг барилдуулах ёстой олон сэжмээр холбоотой юм гэж үзэж байна.

Нүүдлийн соёл иргэншилт монголчуудын хэл ярианд **"бэл", "бэлчир", "бэлчээр"** г.м. дан үгс, **"малын бэлчир", "голын бэлчир", "олон замын бэлчир", "ухааны бэлчир", "оюуны бэлчир", "далны бэлчир", "хэт хутганы бэл", "уулын бэл", "худалдаа арилжааны бэл", "монгөний бэл"** г.м. нийлмэл үгс; **"бэл бэнчин", "бэл хорөнгө", "ус бэлчир", "нутаг бэлчир","бэлчир мэлчир", "оюун бэлчир", "хараа бэлчир"** г.м. хоршоо үгс; **"ухаан бэлчээх", "бодол бэлчээх", "нүд бэлчээх", "бэлчирлүүлэн холбох", "бэлчирлүүлэн давтах", "алсын хараа бэлчир сайтай…", "Бэлийн чулуу оргилдоо дуртай"** г.м. хэвшмэл хэллэг, нэртомьёоны үгс нь хэрэглээний хэлшинжлэл, соёл хэлшинжлэл, угсаа хэлшинжлэлийн талаасаа өвөрмөц ялгаа, өнгө аяс, давтамжийг илэрхийлэхийн хамт сэтгэлгээний өргөн цараатай утга санаа бүхий эрчимлэг агуулгыг түүхэн явцад цогцлоосон шинжтэй байна.

Тайлбар толь бичгүүдэд тэмдэглэснээр бол, **"бэлчир"** хийгээд **"бэлчирлэхүй", "бэлчирлүүлэхүй"**-н утгыг **"уулзвар", "пийлбэр", "голч", "мөчир салаа"** гээд, **"олон замын бэлчир", "голын бэлчир", "малын бэлчир", "ухааны бэлчир", "судасны бэлчир"** г.м. жишээ татжээ. Тиймээс ч бичиг зохиолын найруулгад **"Гурван голын бэлчир", "Гурван Тамирын бэлчир", "Заг-Байдрагийн хүрэн бэлчир", "Орхон-Сэлэнгийн бэлчир"** г.м. нийлсэн орон зайн утгаар хэрэглэгдсэн байхаас гадна, бас **"Монголын нууц товчоо"**-ны 194-р зүйлд:

---

[1] ШУ-ы доктор, профессор. МУБИС-ийн Монгол судлалын сургууль.

Жирэмсэн эмийн шээх газраас
Хол яваагүй
Жижиг тугалын **бэлчих газраас**
Гарч үзээгүй
Эм Таян зүрх алдаж…" гэж Эцэг Таян ханыг зүрх зориггүй, юм үзэж нүд тайлаагүй, хүн болохуйн ухааны бэлчир тааруухан гэсэн санаагаар дүрсэлсэн буй. Бас **"Бие нь бага боловч бэлчир нь яггүй эр…"** г.м. хэллэгт дээрхтэй утга эсрэгээр хэрэглэсэн жишээ баримт зэрэг нь нэг юм хэлээд байх шиг санагдана. Нүүдэлчин монголчууд **"бэлчир"** гэдэг үгийг **"орон", "олон цэгийн уулзвар", "дүрсийн цэгц"** гэсэн утгаар, харин **"бэлчээр"** гэдгийг **"талбай", "нүдэнд ил харагдах гадаргуу"** гэсэн утгаар ойлгож иржээ. **"Бэлчирлэхүй"**-н түүхэн үүдэл нь **"бэл"**-ээс эх авч, утгын цараа нь тэлж эрчимжсэн байна.

2. "Бэлчирлүүлэхүй"-г үзэх монгол ухаанаас үүдүүлэн…

Нүүдлийн соёл иргэншилт монголчуудад **"бэлчир"** хийгээд **"бэлчирлэхүй", "бэлчирлүүлэхүй"**-г үзэх үзэлт, амьдрах ухаан, арга билиг, иргэний эгээрэл гэгээрлийн зүйлс нь байгаль орчны болон хүн-нийгмийн харилцааны үлэмж олон салаа салбарт янз бүрийн хувилбараар илэрч, мэдлэг-мэдээллийг тээж, уламжлагдан ирсэн ажээ. Эдгээрийн зарим нэг сонирхолтой эш баримтыг байцаан сонирхож, соёл-хэлшинжлэл, угсаа-хэлшинжлэл, танин мэдэхүйн хэлшинжлэлийн талаас товчхон сонирхож үзэв.

- Нүүдлийн соёл-иргэншилт монголчууд тулгын гурван чулууны эс бөгөөс ган болд тулгын тэхий дундах уулзвар дээр төмөр мэт хөх хомоолыг зэрэглэн өрж, **гал голомтоо бэлчирлүүлэн бадрааж,** галаа манаж, галыг тахисаар ирсэн нь тун эртний улбаатай ёс заншил аж.
- Эсгий туургатан монголчууд, танан цагаан гэрийнхээ тоонон цамхраанаас алтан нарны цацрагийг **бэлчирлүүлэн,** цагийн хүрдийг товчоолон тоолсоор ирээгүй, өдгөө, өнгөрсөн гурван цагийн орчил дунд, ертөнцийн нэгдмэл орон зайд амь зуусаар ирж.
- Бас тэгээд, нүүдэлчин монголчууд дөрвөн зүг, найман зовхис-орон зайн орчилд таван зүйлийн мал сүргээ адгуулан маллаж, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааг **сэлгүүлэн бэлчирлүүлж**, аж ахуйгаа эрхлэн, амьдарч, нийгэмшиж ирж.
- Монголчуудын ээжийн бүүвэйн дуу, элбэрэлт эцэг эхийн үг сургаал, эрдэмт гэрийн багш, дуулгаварт номхон гарын шавь, номын ухаанд ахин дэвшиж бэдэрдэг дамжаа барих ёсон, хүмүүн байхын гэгээрлийг олдог танхимын ба танхимын бус сургалт зэргийг харсан ч бас л **"бэлчирлүүлэн салаалах"** зам мөртэй гэгээрэл боловсрол байжээ гэж болмоор.
- Монголчуудын **"нүүдэл", "суудал"** хоёр ч ерөөсөө л **"нүүх", "суух"**-ын уулзвар, бэлчир дээрээс арга билгийг олж харсан, **"бэлчирлэхүй"**-н монгол ухаанд шүтсэн соёл иргэншил, амьдрах ухаан юм гэж хэлж болмоор.
- Монгол шатрын хөлөг – буудал дээрх алдах – хожихын нүүдэл, суудал ч мөн л **"бэлчирлүүлэхүй"**-н арга ухаан, хам хүрээнд шүтэлцсэн байдаг нь сонин. Наанадаж бодоход л, боднуудын нөмөр нөөлөгт дулдуйдаж явдаг **"хүүгийн бэлчирлэсэн түлхэлтүүд"**-ээс өгсүүлээд л **"өнчин хүүгийн өлөн цод"** хүртэл арга билгийн ёсонд тэрчлэн, морь, тэмээ, тэрэг, бэрсний хараа хамгаалалт, нүүдлийн **бэлчирт шүтсэн байдаг билээ.** Тиймээс ч монгол хүн, шатрын 64 буудал дунд ухаан бэлчээж сууна хэмээн ярилцаж хэлэлцдэг билээ.

• Мөнх хөх тэнгэрийн буюу **"Шүтэлцэн багцрахуйн"** үзэлт (Акад. Б.Жадамбаагийнхаар), нүүдэлчин монголчуудын уг язгуур, ураг төрөл, эш удмын үзэл санаа, домгийн сэтгэлгээ ч **"мөчирлөхүй"** хийгээд **"бэлчирлэхүй"**-н арга ухаантай нягт шүтэлцээтэй юм гэж хэлж болно. Тухайлбал, Тэмүжиний уг гарвалыг **"Монголын нууц товчоо"**-ны 1-р зүйлд: **"Чингис хааны язгуур, дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ-чино, гэргий Гуа-Маралын хамт тэнгис далайг гэтэлж ирээд, Онон мөрний эх – Бурхан Халдун ууланд нутаглаж, Батцагаан гэдэг нэгэн хөвүүнийг төрүүлэв"**- гээд, цааш нь Чингис хааны алтан ургийг тэрхүү эцэг ба эхийн уулзвар –бэлчрээс залгуулан, 2, 3, 4-р зүйлд: **Батцагааны хөвүүн Тамача, Тамачийн хөвүүн Хоричар мэргэн, Хоричар мэргэний хөвүүн Уужим буурал, Уужим буурлын хөвүүн Саль-Хачау, Саль-Хачаугийн хөвүүн Ихнүдэн, Ихнүдэний хөвүүн Шинсочи, Шинсочийн хөвүүн Харчу, Харчугийн хөвүүн Боржигдай мэргэн бүлгээ. Боржигдай мэргэний гэргий нь Монголжин гуа. Түүнээс төрсөн хөвүүн Торголжин баян. Торголжин баян, Борогчин гуа гэргийтэй, Боролдай Суялби гэдэг залуу зарцтай, дайр бор хоёр хүлэг мортой бүлгээ. Торголжин баяны хөвүүн Дува сохор, Добу мэргэн хоёр бүлгээ. Дува сохор, магнай дундаа ганц нүдтэй, гурван нүүдлийн газар харах бүлгээ…** гэх байдлаар **Бөртэ Чоно, Гуа Марал хоёроос эх аван, мөчирлүүлэн бэлчирлүүлж өгүүлсэн байдаг нь** билгийн сэтгэлгээний нэгэн сонин сайхан баримт болж үлджээ.

• Нүүдэлчин монголчуудын уртын дууны эгшиглээс, ая дан, амьсгаа авалт, түрлэг; хөөмийн түрлэг, хархираа хүрхрээ; морин хуурын татлага, эгшиглэхүй; эв эеийн түмэн өлзий хээний сүлжилдээн, өртөө улаа, түүний буухиа; хурдан морины сунгаа, тарлаа, хүүхдүүдийн зээн гоо; хонь малыг холбох, зэллэх, унгас ноос савах, эсгий хийх, түүдэг хийх, дээс томох, утас ээрэх, сур элдэх, чөдөр ногт зангидах, нүүдэлчдийн тэргэний дугуй, хөсгийн түүчээ, тэмээн жин, мал бэлчээх хариулах, ширдэг ширэх тэргүүтэн олон янз үйл - соёлын зүйл нь цөм л монгол хүмүүний **"холбон бэлчирлэхүй"**-н эрдэм ухаан, арга билгийн ёстой шүтэлцэн уламжлан хөгжиж иржээ гэж хэлэх үндэстэй байгаа юм.

Монгол морин хуур, уртын дууны тухайд гэхэд, МУИС-ийн багш, профессор О.Лхагва: "Мөнх Тэнгэр бол оюун ухаарлын дээд төлөвт Орчлон, байгаль, хүмүүн хийгээд аливаа юмсын мөнх хувьсан улирахын жамыг билиг, дээд ухаарлаар мэдэрч таньсны ачаар их талынхны дунд мянга мянган жилээр цэгцэрч товойсон ариун сургаал мөн. Монголын ардын урлаг, соёл нь одоо ч хүний сэтгэлийг хөглөн, оюун билгийн үүдийг нээж, Орчлонгийн бүтэц, зохицол хийгээд хувьслын найраг сайхныг дээд хэмжилд мэдрүүлж буйг яахин үгүйсгэнэ. Морин хуур, уртын дууны яруу аялгуу хязгааргүй "талаас" үзүүр нь үгүй өндөрлөг рүү шуранхайлахдаа ариун амгалан руу шатлан өгсөх Гэгээрэлийн далд ундарга лугаа нэгсэн хамсахын жаргал эрэлхийлэлд талын хүмүүнийг хүргэдэг л болов уу даа гэмээр. (О.Лхагва, 2003, т.101) гэж тэмдэглэсэн нь сонин сайхан санаа юм.

Бас нэгэн жишээ болгож, монгол ширдэг ширэх соёлын **"бэлчирлүүлэхүй"**-н монгол ухааныг урансайхнаар дүрсэлж, утга төгөлдөр хэлсэн, МУ-ын соёлын гавьяат зүтгэлтэн, нэрт найрагч Гомбожавын Мэнд-Ооёогийн **"Ээж минь ширдэг ширж байна"** хэмээх сонин сайхан шүлгээс татаж үзье. **"Алтан овооны шаштир"** (2008) номд буй **"Ээж минь ширдэг ширж байна"** шүлэгт:

Налайсан шар намрыг цагаан эсгий дээр өнхрүүлж,
Чилийсэн урт өдрүүдийг утасны учгаар хэлхэж,

Намар оройн тэнгэр дор нум сум шиг бөгцийн суугаад,
Наян насандаа ээж минь ширдгээ ширсээр байна.
Тоонын дунгалаар наран шагайхуйд нэг алхам ширээс...
Тогоотой цай дэврэхийн өмнө хоёр алхам ширээс...
Дөрөлжөөр морьтой хүн гарч ирэхүйд гурван алхам ширээс...
Дөрөөн таваг гадаа жингэнэхүй дөрвөн алхам ширээс...
Тэнгэр үүсгүүртэй эсгий дээгүүр ертөнцийн учиг
Тэртээд үлдсэн он жилүүдийг тэмээн жин шиг хөтөлжээ...

гэж монголчуудын ширдэг ширэх урлахуй ухаан, уран үйлийн аргыг он цаг, орон зайн орчил, хөгжилд нь **"бэлчирлүүлэн холбож"** үнэхээр монгол ухаанаар зохист сайхан найруулан дүрслээд, зохиогчоос "Ээж минь ийнхүү намар эхэлсэн үйлээ өвөлжин, хаваржин, зунжин мэтгэж, дараа намар нь хүргээд, сүүлчийн учгийг хөвөрдөн татаж, бөхлөн зангилахдаа дөрвөн цагаар сүлжсэн хорвоон гүн ухааныг судар номд бичих мэт ширдэгнийхээ ширээс бүхэнд туурвин бүтээж, бидэндээ өвлүүлсэн нь энэ буюу... Одоо би ээжийнхээ ширсэн ширдэгний хээ сүлжээс бүхнийг нэгд нэгэнгүй харж, хөлгөн их түмнийхээ оюун билгийн эрдэм ухааныг тэрхүү эсгий номоос уншиж суунам. (171-р тал) гэж дорнын гүн ухаант монгол хүн, монгол найрагчийн сэтгэлээс, уран дүр, дүрслэлээр бэлчирлүүлэн хэлсэн буй. Ургуулан бодохуйн энэхүү зохицол нь бидний сонирхоод байгаа **"бэлчирлүүлэхүй"**-н зарчимд нийцэж, чухам л ая дан нь тохирчээ. Бас жирийн нэг жишээ сонирхъё л доо, монгол аргаар сур элдэх арга барил ч нэг уулзвар буюу нэг цэгт хүндрүүлсэн тээгнээс нар зөв нэг **"бэлчирлүүлэн"**, нар буруу нэг **"бэлчирлүүлэн"** эргүүлсээр, зүссэн сураа зөөлрүүлэн, элдэнгий нь хангаж, эр хар сурыг боловсруулдаг тийм соёлын зүйл байдаг.

Монголчуудын эрдэм ухааны уламжлал, ургуулан бодохуй, түгээж үзэх ёсон (универсализм), хийсвэрлэн бясалгахуй хийгээд "их таван ухааны ай сав"-аас "бага таван ухааны орон"-г бэлчирлүүлэн бүтээж цогцлоосон түүх, их хөлгөн судруудыг туурвисан ба номын утгыг төгс шинжихгүй зэрэг нь цөм л **"бэлчирлүүлэхүйн"**-н монгол ухаан, арга зарчимтай холбоотой ажээ.

Тэрхүү бэлчирлэсэн их таван ухаан нь **"дотоод ухаан"** хэмээх бурханы шашны ухаан, **"дуун ухаан"** хэмээх хэлшинжлэлийн ухаан, **"тэмдэгт ухаан"** хэмээх гүн ухаан, **"тэжээх ухаан"** хэмээх анагаах ухаан, **"урлах ухаан"** хэмээх зохион бүтээх ухаан; бага таван ухааны орон гэдэгт **"зохист аялгуун"** хэмээх яруу найргийн ухаан, **"илт өгүүлэхүй"** хэмээх ёгт үгийн ухаан, **"эвсүүлэн найруулахуй"** хэмээх санскрит, төвд хэлний шүлэглэлзүйн ухаан, **"одон зурхай"** хэмээх тэнгэр эрхэс, одон гарагийн хөдөлгөөн байрлалын ухаан, **"дууриал бүжиг"** хэмээх бүжиглэх жүжиглэхийн ухаан (Л.Хүрэлбаатар, "Огторгуйн цагаан гарди-I", Уб., 1996, 43, 59-р тал) гэх зэргээр салбарлаж, их, бага таван ухаанд хэтэрхий нэвтэрсэн бандид нар төрөн гарч, хоосон чанар, төв үзлийн уудам орон зайд зохиол бүтээлээ туурвин иржээ.

3. Үг ба утгыг найруулах аргаас бэлчирлүүлэн...

Монгол хүмүүний сэтгэлгээний цар хүрээ, эрдэм ухаан, хийсвэрлэх арга нь хэлсэтгэхүйн холбоогоор илэрхийлэгдэж байдаг. **"Зохист аялгуун"**-ы чимгийн зарчим, хос ёсны арга ухааныг гарамгай эзэмшсэн Хамбо номун хан Агванхайдав (1779-1838) тэргүүтэн "Үйлдэхүйеэ бэрх дөрвөөр хосолсон яруу найргийн үзэсгэлэнт чимгийн сургаал"-ынхаа төгсгөлийн шүлэгт:

Үгийг найруулах гэгч үйлдэхүйеэ бэрх үзэсгэлэнт чимэг мөн.

Утгыг найруулах гэгч уйдал үгүй анхааран авахын ёсон мөн. гэж номложээ. (Л.Хүрэлбаатар, "Огторгуйн цагаан гарди" I, 1996, х.89) Эндээс ургуулан бодохуй дор монгол хүмүүний хэлэх, түүнийг нь хэсэглэн хуваах, хэлбэр ба утгаар дэлгэрүүлэн, эсвэл хураан найруулах ёс нь (акад. Ш.Лувсанвандан, Б.Ринчений бичиж тэмдэглэснээр) ер нь л **"бэлчирлүүлэхүй", "эс бэлчирлүүлэхүйн"** арга ухаанд дулдуйдсан байдгийг орчин үеийн бичгийн хүмүүс гэх утгаараа ч Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Л.Түдэв, Л.Хүрэлбаатар… тэргүүтний зохиол туурвилын хэл найруулга бэлхнээ хэлээд өгч байна. Тэгэхлээр бодит байдал буюу байгаль, нийгмийн түм буман юм, үзэгдлийг хөдөлгөөн, орон зай, цаг хугацаа, тоо чанар, дүрс хэлбэрээр нь тусгаж дохиожуулсан хүний хэл нь өөрөө **"бэлчирлүүлэхүй"**-н арга ухаанаар дамжин хэлбэршиж байдаг гэж хэлж болно. Академич Б.Жадамбаа: Монголын уламжлалт ертөнцийг үзэх үзлийн үндсэн зарчмын тухайд холбогдуулж: "Ертөнц-хамаг бүгдийн эелдэхүй, түүний үр болох нэг амь буюу амин нэгдэл. Алив юмс эелдэхлээрээ хүчтэй, тогтвортой, тэнцвэртэй болдог. Юм, үзэгдлийн эелдэхүйг гэрэл (мэдээлэл) тээдэг, зөөдөг, дамжуулдаг. (Б.Жадамба, 2009, т.128) гэсэн нь бидний сонирхоод байгаа "бэлчирлүүлэхүйн монгол арга ухаан" гэдэгтэй холбогдоод ирж байна.

XX зууны монгол хэлшинжлэлийн нэрт эрдэмтэн, акад. Ш.Лувсанвандан: "Байгаль, нийгмийн юм үзэгдэл хүний хэлэнд үлигэр нь болдог", "Хүний хэл нь байгаль, нийгмийн юм, үзэгдлийн аль алинтай нь нягт уялдсан маш нарийн төвөгтэй үзэгдэл юм." гээд, "Хэл бол эвдрэх бүтэх хоёр, салах нийлэх хоёр, тархах хурах хоёр, тасрах үргэлжлэх хоёр, хөдлөх зогсох хоёр, эсрэг тэсрэг хоёр талын нэгдэл юм." (Хэл, хэлэх хоёрын учир, "МС", ¹ 9, х.25; Хэл дохионы тогтолцоо болох нь, "ХЗС", ¹ 10, х.21.) г.м. –ээр дурдсан нь бидний судалгаа, ажиглалтыг батлахад онол – аргазүйн үндэс болж байна.

Монгол хүний хэлэх өгүүлэхүйн түвшинд үгийг найруулах, утгыг найруулах, **"бэлчирлүүлэн"** холбохын сайхан жишээг бид Д.Нацагдоржийн "Миний нутаг" шүлгээс Ц.Дамдинсүрэнгийн "Нарсны навчийг шарлаад байхад…" шүлгийг хүртэлх проф. Л.Хүрэлбаатарын "Огторгуйн цагаан гарди" судалгааны бүтээл, Б.Ринчений **"Юуны магад…"** гэдэг таталбараас Л.Түдэвийн "Хувьсгал танаа өчье!" хэмээх өчил романыг хүртэлх өдий төдий том, бага зохиолын зохиомж, хэл найруулгаар баталж болно. Тухайлж Б.Ринчений **"Юуны магад…"**–ыг харъя:

Цаст уулын оргилоос цагаан болъюу, толгой минь. Тэгээд мөнх билгийн лянхуа цэцэг сэтгэл зүрхэнд минь дэлгэрэнхэн цэцэглэж магад буюу. Тэгвэл гайхамшигт сайхан цэцэгсийн анхилмал үгээр намайг сургаж хүмүүжүүлсэн багш нарынхаа ачийг нь магтан хариулъюу.

Эндээс юуг харж болох вэ? гэвэл энэхүү бичил эхэд өгүүлбэрийн эх бие –бүтцийн загварыг нь (структурный каркас) өгүүлэгдэхүүн (**S**) ба өгүүлэхүүнд (**P**) нь шүтүүлэн, баруун гарын дүрмээр мөчирлүүлэн дэлгэрүүлэхдээ дэд гишүүдийг хүртээж, улмаар нэг өгүүлбэртэй нөгөө өгүүлбэрийг нь хэлбэр ба утгаар нөхцөлдүүлэн, нэг санаанаас нөгөө санааг ургуулан, бэлчирлүүлж дэлгэрүүлсээр зорьсон санаа, гол санаа, шургуулсан санаагаа зохиогч илэрхийлжээ. Чингэхдээ дотоод, гадаад холбох хэрэглүүрийг ашигласан ба **"тэгээд", "тэгвэл"** гэдэг холбох үгс маш чухаг үүрэгтэйгээр оржээ гэж үзэх жишээтэй.

Ер, монгол хэлний өгүүлбэрийн гол хоёр цөм бүрэлдүүлбэрийг баруун гарын дүрмээр хэлбэрээр ба утгаар бэлчирлүүлэн дэлгэрүүлдгийг **"Арлааны Эрдэнэ-Очирын цуглуулсан хорвоо"** дахь **"Сар шагалзана.", "Одон мичид унана.", "Цахлай**

ниснэ.", "Эрхэс ярилцана.", "Амрагууд бичнэ.", "Долгис арчина.", "Хөлөг зүүрмэглэнэ." г.м. цөм өгүүлбэрийг дэлгэрүүлж, уянгын зөөлөн аяс, гүн бодрол, монгол ухаанаар илэрхийлсэн байгалийн зураглалыг урансайхнаар хэрхэн бүтээснийг харж болно. Тэрхүү олон зүйл зохилдон жигдэрч, утга санаа нь мөчирлөн бэлчиж дэлгэрсэн сонин сайхан шүлэг нь:

...Үүлэн завсраар саран шагалзах үдшийн
Үүрэглэх ахуйд од мичид далайд унана.
Тэртээд усны мандлыг цахлай алгадан нисэхүйд
Тэнгэрийн эрхэс далайн сувдтай ярилцана.
Завин дээр суусан хоёр амраг
Шинэхэн хайрын туульсыг усан дээр бичнэ.
Замбуулинд мөнхийн хайр үгүй гэх шиг
Долгис түүний нь арчина.
Атиран гүвэлзэх их усны захад
Аргамжаатай хөлөг онгоц зүүрмэглэнэ... (А.Эрдэнэ-Очир).

Бас тэрчлэн Монгол улсын нэрт эрдэмтэн, доктор, профессор Л.Хүрэлбаатарын **"Огторгуйн цагаан гарди-I"** (Уб., 1996), **"Огторгуйн цагаан гарди-II"** (Уб., 2008) хэмээх цогц хоёр бүтээлийн зохиогуй, бүтэц, агуулга, туурвисан арга ухаан, холбон найруулсан зарчим тэргүүтэнг ажиглаваас XYII, XYIII, XIX зуунд хамрагдах төвд хэлт номын мэргэд, огторгуйн цагаан гардийн сүрэг лугаа адил эрдмийн бурхадын зохиол бүтээлийг задлан шинжлэхдээ одоо хүртэл төдийлөн хийж чадаагүй байсан олон сонин задаргаа, тайллыг орон зай, он цаг, тоо чанарын орчил зайцад нь айхавтар нарийн бодолцсоноор шашин номын нэрт зүтгэлтэн, дуун ухаан, утга соёл, урлахуйн ухааны оюуны амыг нээгч мэргэн, Төв халхын Өндөр гэгээн Занабазараас эх авч, тасралтгүйгээр **бэлчирлүүлэн**, Зая бандид Лувсанпринлэй, Эрдэнэ мэргэн бандид Ишсамбуу, Догшин ноён хутагт Данзанравжаа..., Ханчин Хамбо Жамъянгарва..., Ламын гэгээн Лувсанданзанжанцан... г.м.-ээр залган бэлчирлүүлсээр, II ботьдоо Дорно цастын мөнгөн суварга хэмээгдэх Халхын Сэнгээ гэвш (1905-1993)-ээр өндөрлөн завсарласан буй нь бидний сонирхоод байгаа **зохиомж, байрлал, хэлбэр, утга санаагаар** нөхцөлдүүлэн холбож, бэлчирлүүлэн найрсуулж, эх бичвэрийг бүтээж болдгийн сайхан үлигэр жишээ болсон байна гэж үзлээ.

4. Залган давтах буюу бэлчирлүүлэн давтах ур маягаас үүдүүлэн...

Өмнө, бидний сонирхоод байгаа, үлигэр загвар болгоод байгаа монгол хүний ахуй-сэтгэлгээний зарим илэрхийлэл, эрдэм ухааны арга туршлага, оюуны ба биет соёлын зүйлс нь ерөөсөө л монгол хэлийг тээгчийнхээ хэл-сэтгэхүй, соёлын илэрхийлэлтэй холбоотой, уг чанараараа оюун тархинд нь суулгаастай, төрмөл шинжтэй зүйл болой.

Чухам тийм учраас ч хэл-сэтгэхүйн ба соёлын тэрхүү илэрхийлэл нь монгол хүний ярих хэлэх, бичих найруулах арга ухаан, туурвилзүй, чимгийн зарчим, эх бичвэрийг дэлгэрүүлж, хурааж хувиргах болон холбон найруулах арга хэрэгслээр биежиж илэрдэг тийм онцлог шинжтэй болох нь ажиглагдав. Үүний тодорхой жишээ баримт бол **"Залган ахиулсан давталт"** буюу **"бэлчирлүүлсэн давталт"** гэсэн монгол хэлэн дэх давталтын бие даасан тусгай хэв маяг юм. Үүнийг бид **"Монголын нууц товчоо"**-ноос наашлуулаад, орчин цагийн урансайхны болон бусад зохиол бүтээлийн олон баримтаас цаашлуулаад батлан харуулж болох юм. Тухайлбал, Алтан төрийг хатуужин дагавал **ариун нэр бэхэжнэ. Ариун нэрийг бэхэлбэл** авсан эр ангид үл болно. (М.Н.Т.),

Эрхийн толио шиг мөсийг
Эмтлэн эмтлэн хайлууллаа.
Эмтлэн эмтлэн хайлуулах нь
Тэвнийн сүвэгч шиг халбагаар
Тэнгис ширгээхийн дайтай. (Т.Галсан),
Амар гэдэг нэртэй хөөрхөн хүүтэй болоод,
Аргалчин ээжийнхээ ачийг эргэж нэг дурсав.
Аргалчин ээжийнхээ ачийг эргэж нэг дурсахдаа
Тэртээ уулын бэлээс үүрч ирдэг байсан
Тэмээн жингийн аргийг нь харах шиг болов. (Б.Явуухулан),
Аранзал зээрд мориороо
Алхуулан **шогшуллаа.**
Шогшуулснаа дэргүүллээ.
Дэргүүлснээ ергүүллээ.
Ергүүлснээ хатирууллаа.
Хатируулснаа давхиуллаа (Ж.Дашдондог) г.м.

Дээр өгүүлсэн мэт зүйлс бол наад захын баримтууд бөгөөд монгол урансайхны найруулгад, монгол утга соёлын илэрхийлэлд бүхэл бүтэн шүлэг зохиолыг хүртэл **"бэлчирлүүлэх давталт"**-ын ур маягаар бичсэн сонин баримт олон байгаа юм. Үүнд бид, Б.Явуухулангийн **"Реквием"**, М.Цэдэндоржийн **"Есөн өнгийн чулуу"**, Дан.Нямаагийн **"Тал нь..."**, Даг.Жамъянгийн **"Марал бугын дуу"** зэрэг олон шүлэг зохиолыг дурдаж болно. Жишээлбэл, Даг.Жамъянгийн **"Марал бугын дуу"**-нд:

Марал бугын дууг сонсох гэж
Манант уулынхаа бэлийг барьж өгсөв.
Манант уулынхаа бэлийг барьж өгсөхөд
Магнаг цэнхэр тэнгэрийн хаяа шаргалтав...

гэж дүрсэлсэн байхад, Дан.Нямаагийн "Тал.."-д:

Хөх тэнгэрийн тал нь
Хөлөн буйрын тал.
Хөлөн буйрын тал нь
Олон бухын тал.
Олон бухын тал нь
Миний Мэнэнгийн тал.
Миний Мэнэнгийн тал нь
Мэлтийгч тэнгэрийн тал.
Мэлтийгч тэнгэрийн тал нь

Миний Монголын тал. гэж маш өвөрмөцөөр "залгаж буй, залгагдаж буй хоёр бүрэлдүүлбэрийг маш зохистой тэнцвэржүүлэн, зөөвөрлөн бэлчирлүүлж утгаар ба хэлбэрээр холбосон байдаг. Энэ бол найруулга тэгшитгэх, шүлгийн холбоцыг өрөөсгөл ондгой сондгой болгохгүй **"тэнцвэртэй"**-гээр найруулах зарчмын нэгэн хэв маяг болно гэж үзэв.

ДҮГНЭЛТ

- Монгол хэлний **"бэлчир", "бэлчээр", "бэлчирлэхүй", "бэлчирлүүлэхүй"** г.м. нэр ба үйлийг зогсонги ба хөдлөнги, арга ба билиг, хэлбэр ба утга, хэрэглээ ба соёлын талаас нь шинжвэл нүүдэлчин монголчууд **"бэлчир"** гэдэг үгийг **"оронлог"** утгаас нь, **"бэлчээр"** гэдэг үгийг **"биелэг – талбайлаг"** утгаас нь, **"бэлчирлэхүй"**–г зогсонги буюу **"оршихуй"** талаас нь, харин **"бэлчирлүүлэхүй"**-г хөдлөнги буюу **"эелдэхүй"** талаас ухаарч, ойлгож хэрэглэж иржээ.
- **"Бэлчир"** хийгээд **"бэлчирлүүлэхүй"**-г үзэх монгол ухаан нь олон талтай, өвөрмөц нэгдэлтэй бөгөөд түүний утга соёлын илэрхийлэл нь цөөнгүй баримтаар батлагдаж байна. Үг ба утга хэм тэгш бэлчирлэн найрсахуй, нэг утгаас нөгөө утга салаалан салбарлаж зохист аялгуун болон бэлчирлэхүй нь нүүдэлчин ахуйн бусад олон хэв маягтай шүтэлцсэний зэрэгцээ нүүдэлчдийн соёлын ай болон хөгжжээ.
- Монгол хүмүүний сэтгэлгээний цар хүрээ, эрдэм ухаан, хэл-сэтгэхүйн холбоогоор илэрхийлэгдэж байдаг тэрхүү **"бэлчирлүүлэхүй", "мөчирлүүлэхүй"**-н монгол арга зарчим нь үг ба утгыг өгүүлбэр болон эхийн түвшинд найруулах аргад нь шингэж илэрдэг зүй тогтолтой байна.
- Монгол хэлэндэх **"залган давталт"** буюу **"бэлчирлүүлэн давталт"** бол давтах, холбох ёсны өвөрмөц сонин тусгай хэв маяг мөн бөгөөд монгол хүмүүний **"бэлчирлүүлэхүй"**-н төрмөл эрдэм ухаантай нь нягт шүтэлцээтэй ажээ. Нүүдэлчдийн нүүдэл цаашлан одох учиргүй бөгөөд өнөөгийн монголчуудын нүдэн дээр нь нэг наашлан, нэг цаашлан мөнхөд бэлчирлэх учиртай болой.

НОМЗҮЙ

1. Л.Хүрэлбаатар, "Огторгуйн цагаан гарди-I", Уб., 1996.
2. Л.Хүрэлбаатар, "Огторгуйн цагаан гарди-II", Уб., 2008.
3. Б.Жадамба, "Шүтэлцэн багцрахуйн үзэл ба хүмүүний хөгжил", Уб., 2007.
4. Б.Жадамба, "Эгоизмээс экоизм үрүү шилжихийг монгол ухаанаар шинжихүй", Уб., 2009.
5. Б.Жадамба, "Тогтворжилт: алив асуудалд Монголын уламжлалт ертөнцийг үзэх үзлийн үүднээс хандахуй, түүний үр", "Мэдээлэл-2009".
6. Ш.Бира, "Их монгол улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд", Уб., 2006.
7. Ш.Лувсанвандан, "Хэл, хэлэх хоёрын учир", "Монгол судлал" цуврал, ¹ 9.
8. Ш.Лувсанвандан, "Хэл дохионы тогтолцоо болох нь", "Хэл зохиол судлал", ¹ 10.
9. Ч.Чимэгбаатар, "Ш.Лувсанвандан ба XX зууны монголын хэлшинжлэлийн сэтгэлгээний зарим асуудал", Уб., 2001.
10. "Монголын нууц товчоо", дөрөв дэх удаагийн хэвлэл, (хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав.), Уб., 1990.

11. Б.Пүрэв-Очир, "Үг, өгүүлбэрийн амьдрал араншин, эрчим энерги, соёл хэрэглээ", YII дэвтэр, Уб., 2009.
12. Б.Пүрэв-Очир, "Монгол хэлэн дэх давтах ёсны тогтолцоо", "Mongolica" Олон улсын монголч эрдэмтний 9-р их хурлын эмхтгэл, Уб., 2006.
13. Б.Пүрэв-Очир, "Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ", 6-р дэвтэр, Уб., 2007.
14. Л.Түдэв, "Үгэн бороо" шилдэг исээнүүд, Уб., 2001.
15. Ц.Сүхбаатар, "Монгол хэлний найруулгазүй", нэмэн засварласан дөрөвдүгээр хэвлэл, Уб., 2004.
16. О.Лхагва, "Хөтөч үзэл ба танин мэдэхүй", "Манай Монгол" сэт., 2003, ¹ 3 (17)
17. О.Лхагва, "Мөнх тэнгэр бол эрдэм ухаан.", Илтгэлүүдийн товчлол, Олон улсын монголч эрдэмтний IX их хурал, Уб., 2006.
18. О.Лхагва, "Их талын нүүдлийн соёлын ундарга", MONGOLIA, Vol. 13(34), 2003.
19. Я.Цэвэл, "Монгол хэлний товч тайлбар толь", Уб., 1966.

SUMMARY

This time we have examined two Mongolian words, the noun "бэлчир" and the verb "бэлчирлүүлэхүй". As we expect, these two words have been keeping and containing unique meanings, functions and nuances from their lexical, semantic, cultural and applied perspectives. They are interrealated, as we have considered, in many ways with the life skills, the relationships between cognitive and conventional modes, educational and cultural practices of Mongolians as owners of their own culture and mother language, also with the maners and ways of word, meaning, sentence and discourse revision in spoken and written languages.

Those two words on which we have made some observations and notes, have been used in conventional speeches of Mongolians as single words, compounds, pair words, idioms as well as scientific terms with unique differences, nuances, natural repetitive gradations and vigorous energies from the perspectives of applied linguistics, anthropology, ethno and psycho-linguistics.

Our analysis on those two words has been made according to (1) these two particular words and their meanings, (2) the conventional view of Mongolians on the verb "бэлчирлүүлэхүй", (3) the ways of revising and refining word and meaning in a sentence, (4) the ways of repeated lines and strokes in a natural gradation in a discourse level, and has been supported and illustraded by a number of samples and facts gained from literary sources starting with the "Secret History of Mongols" and ending with the literary and other genres of modern times.

Finally, we have made some conclusions based on the analysis of the words: (1) the noun "бэлчир" has been understood and used as a concept of "distance and space", the verb "бэлчирлүүлэхүй" as a concept of dynamics, "бэлчирлүүлэхүй" as concept of statics, (2) the point of view of Mongolians on these two words are variable and multilatered, and their representatives have been proved in many literary facts, (3) the principle of natural gradation of lines and strokes in a literary discourse have been revealed and recognized in the ways and techniques of word and meaning revision in any sentence and discourse level.